

Хачгаар дамжин халдварлах өвчнүүдийн хяналт сэргийлэлтийн зөвлөмж

Үндэслэл:

Сүүлийн жилүүдэд хачгаар дамжин халдварлах өвчний тархалт нэмэгдэж, хүний өвчлөл жилээс жилд ихсэх хандлагатай байгаа ба 2009 оны хүний өвчлөлийг өмнөх онтой харьцуулахад 3 дахин, сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 4,2 дахин тус тус өсчээ.

Нэг талаас хачгаар дамжин халдварлах өвчнүүдийн оношлогоо сайжирч байгаа, нөгөө талаас уг өвчний байгалийн голомт тэлж байгаатай холбоотой хүний өвчлөл шинээр бүртгэгдэх нь тасралтгүй нэмэгдсээр байна. Тухайлбал: Архангай, Хэнтий, Хөвсгөл, Баянхонгор, Булган, Өвөрхангай, Төв аймгийн 19 сум, нийслэлийн 2 дүүрэгт хачигт халдвар өвчний хүний өвчлөл 2009 онд шинээр бүртгэгдээд байна.

Иймд уг халдвараас хүн амыг сэргийлэх зорилгоор дараах ажлуудыг аймаг, Нийслэлийн ЭМГ, БГХӨСТ-өөс зохион байгуулан явуулах шаардлагатай байна.

А. Сэргийлэх арга хэмжээ:

Өвөрмөц урьдчилан сэргийлэлт:

1. Хачигт энцефалитын эсрэг дархлаажуулалтад голомтот нутгийн хүн ам ялангуяа эрсдэлт бүлгийн хүмүүсийг /малчид, малын түүхий болон дутуу боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэдэг хүмүүс, самар, жимс түүгчид, мод болон эмийн ургамал бэлтгэгчид, зам засвар, уул уурхай, газар шороо, ашигт малтмалын чиглэлээр ажиллагсад, анчид, аялагчид, эмч, эмнэлгийн ажилтан гэх мэт/ хамруулах

2. Дахлаажуулалтад хамрагдаагүй голомтот нутагт ажиллаж буй эрсдэлт бүлгийн хүмүүст нэн шаардлагатай үед хачигт энцефалитийн ийлдсийг урьдчилан сэргийлэх зорилгоор /үйлдвэрлэгчийн зааврын дагуу/ хийх

Өвөрмөц бус урьдчилан сэргийлэлт:

1. Хачгаар дамжин халдварлах өвчний оношлогоо, эмчилгээнд шаардлагатай эд зүйлсийн /хамгаалах хувцас, эм тариа, оношлуур урвалж, шинжилгээний багаж хэрэгсэл, аппарат тоног төхөөрөмж гэх мэт/ бэлэн байдлыг ханган ажиллах

2. Эмч, эмнэлгийн ажилтан нарт хачгаар дамжин халдварлах өвчний талаар сургалт зохион байгуулж, мэдлэгийн түвшинг ахиулах

3. Лабораторид суурилсан тархварзүйн тандалт судалгааны ажлыг зохион байгуулах:

а/. Голомтот нутгийн хүн амыг асуумж судалгаанд хамруулан хачгаар дамжин халдварлах өвчний талаарх дадал, хандлага, мэдлэгийн түвшинд үнэлэлт өгөх, халдварт өртөх эрсдэл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох

б/. Халдварт өртсөн байж болзошгүй (хачигт хазуулан уг өвчний эмнэлзүйн шинж тэмдэг илэрч байсан) хүмүүсээс цусны ийлдэс цуглуулан шинжилж, хүн амын дундах хачгаар дамжин халдварлах өвчний тархалтыг тогтоох

в/. Хачиг цуглуулан зүйлийн бүрдэл тодорхойлох, тархалт, тоошил, халдваржилтыг тогтоож байгалийн голомтын төлөв байдлыг тогтоох

г/. Хачигт халдвар өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэл гаргаж, хүн амын болон байгалийн голомтын халдварын эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах

д/. Голомтот нутгийн хүн амд уг өвчний халдвараас сэргийлэх талаар сурталчилгааны ажлыг зохион байгуулан явуулах (ялангуяа малчид хонь хяргах, ямаа

самнах, самар жимс түүгчид ойд явж байхдаа хачигт хазуулан халдвар авч өвчлөх нь их байгааг анхаарах)

Хувь хүмүүст:

- а/. Хачигт хазуулахаас сэргийлж битүү хувцас /тод өнгөтэй/ өмсөх, 3-4 цаг тутамд биеэ шалгаж хачгийг зайлуулах, хачиг дайжуулагч хэрэглэж байх
- б/. Хазсан хачгийг зайлуулахдаа бээлий өмсөх эсвэл алчуур хэрэглэн хачигны хошууг арьсанд үлдээхгүйгээр болгоомжтой салгаж авах
- в/. Хоол хүнсийг сайтар боловсруулж хэрэглэх, ялангуяа сүүг гүйцэд боловсруулах
- г/. Хүн амд хачигт хазуулсантай холбоотой ямарваа нэг эмнэлзүйн шинж тэмдэг илэрвэл эмнэлгийн байгууллагад яаралтай хандаж байх талаар сурталчилгаа хийх

Б. Халдвар хамгааллын арга хэмжээ:

1. Мэдээлэх:

Хачигт халдварын хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүрийг БГХӨСҮ Төвд 24 цагийн дотор мэдээлнэ.

2. Хачигаар дамжин халдварлах халдварт өвчний хүний өвчлөлийн сэжигтэй тохиолдлыг орон нутагт халдвартын тасагт хэвтүүлэн, лабораторийн шинжилгээ авч шинжлүүлэн оношийг тодруулна.

3. Илрүүлэлт:

Голомтод тархварзүйн тандалт судалгаа хийж, тархвар судлалын холбогдлыг тогтоон лабораторийн шинжилгээнд сорьц авч шинжлүүлэн дүгнэлт гарган ажиллана.

4. Хөл хорио: шаардлагагүй.

5. Эмч, эмнэлгийн ажилтан нар өвчтөнөөс сорьц авах үедээ биоаюулгүй ажиллагааг ханган халад, бээлийтэй ажиллавал зохино.

Жич: “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, Эрүүл мэндийн Сайдын “Хачигт халдварын тухай” 2007 оны 1/1833 тоот албан даалгавар, Эрүүл мэндийн Сайдын 2002 оны 252, 2010 оны 152 тоот тушаал, Хачгаар дамжин халдварлах өвчний оношлогоо, эмчилгээ, тандалтын стандарт MNS 5348-44:2003, MNS 5348-45:2003, MNS 5349-44: 2003, БГХӨСҮ Төвийн захирлын 2008 оны 71 тоот “Хачгаар дамжин халдварлах өвчнүүдийн талаар авах арга хэмжээний тухай” тушаалыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.